

УУР АМЬСГАЛЫН ДИАГРАМ БАЙГУУЛАХ АРГА


Алхам 1

График байгуулахад ашиглагдах сар бүрийн дундаж температур болон нийлбэр тунадасны хэмжээг зурагт үзүүлсэн байдлаар **Excel sheet** дээр хүснэгт болгон бичнэ.

Сар	Температур	Тунадас, мм
I	4.8	59
II	4.9	50
III	6.7	47
IV	9.4	54
V	12.7	57
VI	15.7	60
VII	17.8	59
VIII	17.3	65
IX	15	51
X	11.8	60
XI	7.8	67
XII	5.3	61

Алхам 2

Бэлэн болгосон хүснэгтэн мэдээллээ идэвхжүүлээд **Insert** цэсний **Recommended charts** цэс рүү ороод **All charts** цэсийг сонгоно. Ингээд жагсаалтын хамгийн доор байгаа **Combo** төрлийг сонгоно. Доорх зурагт үзүүлсний дагуу температурыг илтгэх **Chart type**-г **Line** болгоод, тунадсыг **Clustered Column** болгоно. Температурын утга заах тэнхлэгийг гаргаж ирэхийн тулд **Secondary Axis** гэсэн товчийг чагтлаад **Ok** дарахад бидний уур амьсгалын диаграммын ерөнхий хэлбэр гарч ирнэ.



Алхам 3

Графикийг идэвхжүүлэхэд хажууд нь гарч ирэх ногоон “+” тэмдэг дээр дарж **Axis Titles** цэсийг сонгоход 2 босоо тэнхлэгийн гарчиг бичих цонх гарч ирнэ. Үүн дээр температур болон тунадсын утгыг аль тэнхлэг илэрхийлж байгааг ялган бичнэ. Мөн өөрийн хүссэнээр графикт нэмэлт өөрчлөлт хийх бол бусад цэснүүдээс сонгон өөрчилж болно.

